



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2017 оны 09 сарын 07 өдөр

Дугаар 123

Номгон

Хонгор шинэ агро орон нутгийн
өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн
газар байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ын "ж", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээний байгалийн хадлан бэлтгэх, нийлүүлэх, малын тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, газар тариалан эрхлэгчдийг дэмжиж ажиллах чиг үүрэг бүхий Хонгор шинэ агро орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг үүсгэн байгуулсугай.


2. Хонгор шинэ агро орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийг хавсралтаар баталсугай.

3. Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын Төлөөлөн удирдах зөвлөлийг томилохыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд, бүтэц орон тоо, цалингийн санг баталж гүйцэтгэх удирдлагыг томилж, ажлын гүйцэтгэл үр дүнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ОТГОНБАЯР

0117285



**ХОНГОР ШИНЭ АГРО ОРОН НУТГИЙН
ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ДҮРЭМ**

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү дүрэм нь орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлагын бүтэц, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлсон эрх зүйн үндсэн баримт бичиг мөн.

1.2.Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь Иргэний хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль болон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын шийдвэр энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

1.3.Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар /цаашид газар гэх/-ийн үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгч нь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал байна.

Хоёр.Газрын хэлбэр, оноосон нэр, байршил тэмдэг

2.1.Газар нь 100 хувь орон нутгийн өмчит үйлдвэрийн газар бөгөөд бие даасан тайлан тэнцэлтэй, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, ашгийн төлөө хуулийн этгээд юм.

2.2.Газрын оноосон нэр нь "Хонгор шинэ агро" орон нутгийн өмчит үйлдвэрийн газар, товчилсон нэр нь "ХША" ОНӨҮГ байна.

2.3.Газрын төв байрны хаяг нь: Баянхонгор аймгийн Баянхонгор сумын нутаг дэвсгэрт байна.

2.4.Газар нь өөрийн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, харилцах данстай байна.

2.5.Тэмдэг нь тус газрын албан ёсны шийдвэр, албан бичиг, гэрээ, хэлцэлүүдийг баталгаажуулах зорилготой.

Гурав.Газрын үндсэн зорилго, үйл ажиллагааны чиглэл, хугацаа

3.1.Үйл ажиллагааны үндсэн чиглэл

а/Аймгийн хэмжээний хэрэгцээт байгалийн хадлан бэлтгэх, нийлүүлэх /Өвсний нөөц бүрдүүлэх/, малын тэжээлийн үйлдвэрлэл, худалдаа эрхлэх, газар тариалан эрхлэгчдийг дэмжиж хамтарч ажиллах.

б/Эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх.

в/Дотоод, гадаадын байгууллага, компаниудтай хорших, техник технологи, мэдээлэл, мэргэжилтэн, ажилчид солилцох, хамтран үйлдвэрлэл, худалдаа эрхлэх болон бусад хамтын ажиллагааны ашигтай бүхий л хэлбэрүүдийг сонгож хэрэглэх.

г/Өөрийн үйл ажиллагаатай холбогдуулан шаардлагатай хөрөнгө, санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх, энэ зорилгоор санхүүгийн төрөл бүрийн арга хэрэгслүүдийг ашиглах.

д./Хамтран ажиллаж буй аж ахуйн нэгжүүдтэй орон нутгийг төлөөлж харилцах, олох ашиг орлогоос орон нутагт ноогдох хувь хөрөнгийн талаар санал гаргах.

3.2.Газар нь дээр дурдсанаас гадна хуулиар хориглоогүй бусад бизнесийн үйл ажиллагаа явуулах, орлого ашгаа нэмэгдүүлэхийн төлөө ажиллаж болно.

3.3.Газар нь цэвэр ашгийн 50 хувийг орон нутгийн хөгжлийн санд, 30 хувийг техник, технологийг нэмэгдүүлэх, сайжруулах болон засвар үйлчилгээнд, 20 хувийг ОНӨҮГ-ын ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд тус тус зарцуулна.

3.4.Хувь нийлүүлэгчдийн хурлаас газрыг татан буулгахаар шийдвэрлэсэн болон эрх зүйн бусад шалтгааны улмаас тус газар нь үйл ажиллагаагаа цаашид үргэлжлүүлэн явуулах үндэслэлгүй болсноос бусад тохиолдолд үйл ажиллагаагаа хугацаагүйгээр явуулна.

Дөрөв.Дүрмийн сан хөрөнгө

4.1.Газрын хөрөнгө нь

4.1.1.Газрын өөрийн хөрөнгө

4.1.2.Газрын өөрийн хуримтлагдсан ашгаар нэмэгдсэн дүрмийн сан

4.1.3.Орон нутгийн өмчөөс хууль тогтоомжийн дагуу хуваарилагдсан, шилжүүлсэн хөрөнгө

4.1.4.Үйлдвэрлэл, үйл ажиллагааны үр дүнд бий болсон эд хөрөнгө

4.1.5.Бусад эх үүсвэр

Тав.ОНӨҮГ-ын эрх, үүрэг

5.1.Газрын хэлбэрийг өөрчлөх, татан буулгах, газрын дүрмэнд өөрчлөлт оруулах асуудлыг хувь нийлүүлэгчдийн хурал шийдвэрлэнэ.

5.2.Газар нь өөрийн үйл ажиллагаагаа бие даан хуулийн хүрээнд эрхлэнэ.

5.3.Газар нь үндсэн болон туслах үйлдвэрлэл, үйлчилгээний ажлыг хэвийн явуулах зорилгоор мэргэжил чадвар сайтай, дадлага туршлагатай боловсон хүчнийг хөдөлмөрийн гэрээгээр авч ажиллуулж, тэдний ажиллах нөхцөл, хөдөлмөрийн хөлс, урамшууллын хэмжээг тогтооно.

5.4.Газар нь төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, түүнчлэн олон улсын холбогдох байгууллагад гишүүнээр элсэн ашиг сонирхлоо хэрэгжүүлэхэд төлөөлөл оролцуулан хамтран ажиллаж болно.

5.5.Газар нь өөрийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн эзэмшиж ашиглана.

5.6. Газар нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллагсдын өмнө хуулиар хүлээсэн үүргүүдийг биелүүлнэ.

5.4. Газар нь улсын бүртгэлийн гэрчилгээ авсан өдрөөс үйл ажиллагаа явуулна.

Зургаа. ОНӨҮГ-ын удирдлага

6.1. Газрын удирдлага дараах бүтэцтэй байна. Үүнд:

- 1.Хувь нийлүүлэгчдийн хурал
- 2.Төлөөлөн удирдах зөвлөл
- 3.Гүйцэтгэх удирдлага

Долоо.Хувь нийлүүлэгчдийн хурал

7.1. ОНӨҮГ-ын эрх барих дээд байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал /ИТХ/ байна.

7.2.Хувь нийлүүлэгчдийн хурлаас шийдвэрлэсэн асуудлаар тогтоол гаргана. Хурлын явц, хэлэлцсэн асуудлын талаар тэмдэглэл хөтөлнө.

7.3.Дор дурдсан асуудлыг Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

7.4.1.Газрын дүрэм болон дүрмэнд нэмэлт өөрчлөлт оруулах, түүний шинэчилсэн найруулга.

7.4.2.Нийлэх, нэгдэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх хэлбэрээр газрыг өөрчлөн байгуулах.

7.4.3. Газрыг татан буулгах болон татан буулгах комиссыг томилох

Найм: ОНӨҮГ-ын төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх

8.1 Хувь нийлүүлэгчдийн хурлын чөлөө цагт тус газрын эрх барих дээд байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна. ТУЗ нь 5 доошгүй гишүүнтэй байна.

8.2 Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дотроос нийт гишүүдийн олонхийн саналаар сонгоно.

8.3 Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг түр эзгүйд түүний үүргийг ТУЗ-ийн даргын эсхүл ТУЗ-ийн томилсон гишүүн гүйцэтгэнэ.

8.4 Газрын бүтэц орон тоо цалингийн санг батлах.

8.5 Газрын жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хэлэлцэх.

8.6 Газрын салбар болон төлөөлөгчийн газар байгуулах, гэрээ хэлцэл хийх зөвшөөрөл олгох.

8.7 Аудитын байгууллагыг сонгож гэрээ байгуулах

8.8 Газрын эд хөрөнгийг худалдах, эд хөрөнгийн эрхийн зах зээлийн үнийг тодорхойлох

8.9 Газрын хөрөнгийг барьцаалах, зээл авах эрх олгох

8.10 Газрын гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөхөд Засаг даргад санал өгөх

8.11 Газрын хяналтын зөвлөлийг томилж, чөлөөлөх, түүний ажлын төлөвлөгөө, тайланг хэлэлцэх

8.12 Хувь нийлүүлэгчдийн хурлаар хэлэлцэхээр оруулсан бусад асуудал

Ес.Гүйцэтгэх удирдлага

9.1. Газрын гүйцэтгэх удирдлага нь газрын дүрэм болон Засаг даргатай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний дотор компаний өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулна. Газрын гүйцэтгэх удирдлага нь компаний гүйцэтгэх захирал байна. Гүйцэтгэх захирал нь газрын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр салбар болон төрийн өмчийн, хувийн үйлдвэрийн газар, аж ахуйн нэгжид үйл ажиллагаа явуулдаг санхүүгийн ашиг сонирхолтой байж болохгүй.

9.2. Газрын гүйцэтгэх захирлыг аймгийн Засаг дарга томилно.

9.3. Газрын гүйцэтгэх захирлын эрх, үүрэг

9.3.1. Газрын эрх ашгийг дээдлэн тавьж, мэргэжил, ажлын дадлага, туршлагаа бүрэн дайчлан газрын менежментийн бодлого боловсруулан газрыг удирдах.

9.3.2. Газрын хөрөнгийг энэхүү дүрэм, Засаг даргатай байгуулсан гэрээ, хувь нийлүүлэгчдийн хурлаас олгосон эрх хэмжээний дотор эзэмшиж, ашиглах.

9.3.3. Газрын захирлын зөвлөлийг байгуулах.

9.3.4. Газрын үйл ажиллагааны тухайн жилийн зорилтот түвшин, бизнес төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах.

9.3.5 Төлөөлөн удирдах зөвлөлийн өмнө компанийн үйл ажиллагааг бүрэн хариуцаж, жил бүрийн эцэст ажлын үр дүнг тайлагнан дүгнүүлэх.

9.3.6. Энэхүү дүрэм болон холбогдох хууль тогтоомж, норм норматив, хувь ТУЗ-ийн шийдвэр, үүрэг даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж, гүйцэтгэлийг хангуулах.

9.3.7. ТУЗ-ийн хурлаас өгсөн саналын дагуу аймгийн Засаг даргын баталсан орон тоо, зохион байгуулалтын бүтцийн хүрээнд ажилтнуудын ажлын байрны тодорхойлолтыг батлах, ажилтныг ажилд томилох, тэдэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажлаас чөлөөлөх.

9.3.8. ТУЗ-ийн өмнө хүлээсэн үүргийг биелүүлэх, удирдаж буй компанийн санхүү, төлбөрийн чадвар нэр хүндийг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого, үйл ажиллагаа явуулах.

9.3.9. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн хурлын зөвшөөрлийн үндсэн дээр зарим эрх, үүргээ итгэмжлэл гарган газрын холбогдох албан тушаалтанд шилжүүлж болно. Ийнхүү эрхээ итгэмжлэн шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

9.3.10. Газрын үйл ажиллагаатай холбогдох асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах.

9.3.11. Газрыг шинээр худалдан авах болон акталж устгах, худалдах үндсэн хөрөнгө /тоног төхөөрөмж, автомашин механизм, барилга байгууламж/-ийн асуудлыг нэгтгэж ТУЗ-ийн хуралд тавьж шийдвэрлүүлэх.

9.3.12. Эрх бүхий харилцаанд газрыг төлөөлөх.

9.3.13. Хуульд өөрөөр заагаагүй бол өөрийн хууль бус үйл ажиллагаанаас газарт учирсан хохирлыг хариуцах.

Арав. ОНӨҮГ-ын хяналтын тогтолцоо

10.1. Газрын хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна. Үүнд

Өмчлөгчийн хяналт

Хөндлөнгийн аудитор

10.2. Өмчлөгчийн хяналтыг хувь нийлүүлэгчдийн хурлаас томилогдоно. Хяналтын зөвлөл /цаашид "ХЗ" гэх/ хэрэгжүүлнэ.

10.3. Хяналтын зөвлөлийг гурван хүний бүрэлдэхүүнтэй хувь нийлүүлэгчдийн хурлын тогтоолоор томилох бөгөөд хийсэн ажлынхаа тайланг жилд нэгээс доошгүй удаа ХНХ-д тайлагнах үүрэгтэй.

10.4. Хяналтын зөвлөлийн гишүүнд газрын эрх бүхий албан тушаалтан байж болно.

10.5. Газрын хөндлөнгийн хяналт шалгалтыг төрийн аудитын байгууллагаар жилд нэг удаа хийлгэнэ.

Арван нэг .ОНӨҮГ-ын нягтлан бодох бүртгэл, тайлан

11.1. Газар нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, олон улсын нягтлан бодлох бүртгэлийн стандартын дагуу хөтлөн, санхүүгийн тайлан гаргаж, аудитын байгууллагаар дүгнэлт гаргуулан, хувь нийлүүлэгч болон эрх бүхий бусад этгээдэд танилцуулна. Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг газрын гүйцэтгэх захирал хариуцна.

11.2. Газрын санхүүгийн жилийн эхлэх хугацааг тухайн оны 1 дүгээр сарын 01, дуусах хугацааг мөн оны 12 дугаар сарын 31-нээр тогтооно.

Арван хоёр. Газрын санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

12.1. Газрын санхүүгийн тайланд дараах зүйлийг тусгана.

12.1.1. баланс

12.1.2. орлого, үр дүнгийн тайлан

12.1.3. Мөнгөн гүйлгээний тайлан

12.1.4. өмчийн өөрчлөлтийн тайлан

12.1.5. хуримтлагдсан ашгийн тайлан

12.1.6. нэмэлт тайлбар

12.1.7. Бусад

Арван гурав. Газрын бичиг баримтыг хадгалах

13.1. Газар нь дараах баримт бичгийг хадгална.

13.1.1. Газрын дүрэм, дүрмэнд орсон нэмэлт өөрчлөлт, газрыг байгуулах тухай үүсгэн байгуулагчдын хурлын шийдвэр, газрын бүртгэлийн гэрчилгээ

13.1.2. Хувь нийлүүлэгчдийн хурал, Төлөөлөн удрах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон Хянан шалгах зөвлөлөөс баталсан газрын дотоод бичиг барим

13.1.3. Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичиг

13.1.4. Хувь нийлүүлэгчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, гүйцэтгэх захирлын тушаал, шийдвэр

13.1.5.Хяналтын зөвлөлийн хурлын тэмдэглэл, хяналтын зөвлөл болон аудитын тайлан

13.1.6.Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан

13.1.7.Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн бичиг баримт

13.1.8.Бусад баримт бичиг

13.2. Газар нь бичиг баримтыг өөрийн үйл ажиллагаагаа эрхлэн явуулах газарт явуулна.

13.3.Газар нь өөрийн дүрэм, түүний нэмэлт өөрчлөлтийг байнга хадгална. Баримт бичгийг холбогдох дүрэм журам, зааврын дагуу улсын архивт шилжүүлнэ.

Арван дөрөв. ОНӨҮГ-ыг татан буулгах

14.1. Газрыг хувь нийлүүлэгчийн хурал болон шүүхийн шийдвэрээр татан буулгана.

14.2.Татан буулгах комисс томилсноор тухайн газрын гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх дуусгавар болж татан буулгах комисст шилжүүлнэ.

Арван тав. Бусад

15.1.Энэ дүрэмд тусгагдсан зүйлээс бусад асуудлыг Монгол Улсын Компаний тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

_____оОо_____